



МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ГИШҮҮНИЙ ТОГТООЛ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа
үүсгэх тухай

Иргэн Г.Батаа Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж "Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт "50 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан Монгол Улсын уугуул иргэн Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй.", 5.6 дахь хэсэгт "Монгол Улсын иргэний ... сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлах, ... саад учруулахыг хориглоно." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн" гэсэн мэдээлэл ирүүлжээ. Үг мэдээлэлд холбогдох үндэслэл, тайлбарыг тусгаад Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан заалтын холбогдох хэсгийг зөрчсөн эсэхийг Үндсэн хуулийн цэцээс хянан шийдвэрлэж өгөхийг хүссэн байна.

Үндэслэл:

Иргэн Г.Батаагийн мэдээлэлд дурдсан асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх хууль зүйн үндэслэлтэй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

1.Иргэн Г.Батаагийн мэдээллийн дагуу Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.6 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхийлөгчөөр ... зөвхөн нэг удаа сонгоно." гэж заасныг зөрсөн асах асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа тус тус үүсгэгдэй.

ГИШҮҮН



Д.СОЛОНГО

24